



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1998 оны 07 сарын 28

№ 11

Улаанбаатар
хот

Улсын үйлдвэрийн газар
байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Улаанбаатар хотын Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондыг Улсын үйлдвэрийн газраар ажиллуулсугай.

2. Улаанбаатар хотын Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондын дүрмийг хавсралт ёсоор баталж, дүрмийн санг 531,5 мянган төгрөгөөр тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан туслах аж ахуй хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 95 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хүчингүй болгосонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА,

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
Захиргааны 1992 оны
тоот тогтоолын хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН
АЮУЛААС ХАМГААЛАХ ФОНДЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улаанбаатар хотын Малын тэжээлийн аюулаас хамгаалах фонд нь Сүхбаатар дүүргийн ОСГ-ны 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 45-р Гудамжны 635 тоот хашаанд ажил үүргээ явуулна.

2. Малын тэжээлийн аюулаас хамгаалах фонд нь хотын мал бүхий албан байгууллага, иргэдийн туслах аж ахуйг малын тэжээлээр хангах, аж ахуйн тооцоон дээр ажиллаж байгаа улсын үйлдвэрийн газар мөн.

3. Фонд нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд тооцооны харилцах данстай байна.

Хоёр. Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондын үүрэг хариуцлага

1. Хотын малын тэжээлийг аж ахуйн тооцоон дээр үндэслэн жил бүр төлөвлөгөөнд тусган бэлдэж фондлох ажлыг хариуцна.

2. Тэжээл бэлдэх ажлыг байгаль хамгаалах, галын аюулаас сэргийлэх ажилтай уялдуулан зохицуулж ажиллахын хамт чанар стандартын шаардлагыг хангасан байна.

3. Аж ахуйн гэрээний сахилгыг чанд сахиж, санхүүгийн бүртгэл тооцоог үнэн зөв хөтлөн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж байна.

Гурав. Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондын эрх

1. Бусад байгууллага иргэдтэй харилцаж гэрээ байгуулах хэлэлцээ хийх.

2. Байгууллагын эд хөрөнгийг хууль тогтоомжинд заасны дагуу захиран зарцуулах.

3. Ажилчдыг томилох, чөлөөлөх.

4. Хууль тогтоомжид нийцүүлж тушаал заавар гаргах.

Дөрөв. Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондын удирдлага,
зохион байгуулалт

1. Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондын дээд байгууллага нь хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа мөн.

2. Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тушаалаар фондын даргыг томилж байна.

3. Фондын дарга Малын тэжээлийн аюулаас хамгаалах фондын ажлыг шууд удирдана.

4. Байгууллагын ажлыг фондын бүх ажилчдын хурлаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэж байна.

5. Хотын малын тэжээлийн аюулаас хамгаалах фондыг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.